



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 11/2015

Мандалговь

Тусгай зөвшөөрлийн эрх олгох, сунгах тухай

Монгол Улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 7 дугаар зүйлийн 7.2, 7.4, 14 дүгээр зүйлийн 14.1.4, 16 дугаар зүйлийн 16.2.5, "Архидан согтуурахтай тэмцэх тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7, 6 дугаар зүйлийн 6.3, 6.5, 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын "Зоогийн бор овоот" ХХКомпаний "Мандах зоог" зоогийн газарт архи, согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн эрхийг 2017 оны 06 дугаар сарын 12-ны өдрөөс 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийг хүртэл хугацаагаар олгосугай.

Хоёр. Сайнцагаан сумын "Хөүмланд" ХХКомпаний "Эко" хүнсний дэлгүүрт архи, согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2017 оны 06 дугаар сарын 12-ны өдрөөс 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийг хүртэл хугацаагаар сунгасугай.


Гурав. Дэлгэрцогт сумын "Баянбулаг" жуулчны баазуудын согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн эрхийг 2017 оны 06 дугаар сарын 12 -ны өдрөөс 2017 оны 10 дугаар сарын 16-ны өдрийг хүртэл хугацаагаар олгосугай.

Дөрөв. Сайнцагаан сумын "Зоогийн бор овоот" ХХКомпаний "Мандах зоог", "Хөүмланд" ХХКомпаний "Эко" хүнсний дэлгүүр, "Баянбулаг" жуулчны баазуудын ажиллах цагийн хуваарийг 08.00-24.00 хүртэл хугацаагаар баталсугай.

Тав. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон шийдвэрийг холбогдох газруудад хуулийн хугацаанд мэдэгдэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Н.Эрдэнэ-Очир/, тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар /Б.Очирдорж/, Татварын хэлтэс /М.Туяацэцэг/, Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/, холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



0200596